

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 сарын 28 өдөр

№ 01.

Дархан уул аймаг

“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025.04.28-ний өдрийн 14<sup>00</sup> цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 156153 ширхэг саналын эрхтэй 3 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 95.5%-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Ж.Очирсүхийг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
3. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн Д.Бумцэрэн нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хараат бус гишүүн Д.Бумцэрэн: “Тээвэр Дархан” ХК-ний ТУЗ-ийн хараат бус гишүүд бид компанийн тухай хуулинд заасан эрх үүргийнхээ хүрээнд тус компанийн 2024 оны, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж санхүүгийн тайлангийн борлуулалт, үйл ажиллагааны зардлыг харахад алдагдалтай ажилласан байна. Өнгөрсөн онд ашигтай ажилласан бол энэ онд алдагдалтай ажилласан нь засвар үйлчилгээний материалын үнэ нэмэгдсэн мөн цалингийн зардал өссөнтэй холбоотой харагдаж байна. 2024 онд гарсан нийт үйл ажиллагааны зардлын 32.3% ийг үйлчилгээний зардлуудын гол зардал болох урсгал засварын зардал 23.6% ийг цалингийн зардал, 12.4% ашиглалтын зардал эзэлж байна. Компанийн мөнгөн эх үүсвэрийг бүрдүүлдэг зах худалдааны төвүүдийг түрээслэгч хамт олныхоо санаа бодлыг сонсож ажлын байр, ая тухтай ажиллах нөхцөл бололцоог анхааралдаа авч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Цаашид компанийн үйл ажиллагааг тогтвортой зөв менежментээр удирдан зохион байгуулж компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх хөрөнгийн ашиглалтыг сайжируулахад анхааран ажиллах нь зүйтэй байна.

Компанийн ерөнхий нягтлан бодогч Бямбажаргал: Тайлангийн жилд компанийн үйл ажиллагааны мөнгөн эх үүсвэр нь Шинэ зах, Буян зах, Дархан зах худалдааны төвийн түрээсийн орлогууд болон дэлгүүрийн борлуулалтын орлогоос бүрдэж байна. 2023 оны борлуулалт 4094.7 сая төгрөг байсан ба 2024 оны нийт борлуулалтын орлого 4538.0 сая төгрөг байна. Үүнээс харахад 2024 оны борлуулалтын орлого өмнөх жилээс 443.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Тайлант жилд 4575.4 төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан байна. 2024 онд гарсан нийт үйл ажиллагааны зардлыг 2023 онтой харьцуулахад 848.7 сая төгрөгөөр өссөн нь нийт зардлын 32.29% ийг эзэлж буй засвар үйлчилгээний материалын үнэ нэмэгдсэн, цалингийн зардал өссөнтэй холбоотой харагдаж байна. 2024 онд гарсан нийт үйл ажиллагааны зардлын 32.29% ийг үйлчилгээний заалуудын гол зардал болох урсгал засварын зардал 23.55% ийг ажилчдын цалингийн зардал 12.39% ийг ашиглалтын зардал эзэлж байна. Тайлант жилд 756.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгээр үндсэн үйл ажиллагаагаа явуулж 4538.0 сая төгрөгийн орлоготой 4575.3 сая төгрөгийн зардал гарч -129.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тайлант жилд НӨАТ-т

217.9 сая төгрөг, ХАОАТ-т 67.7 сая төгрөг, ААНОАТ-т 17.4 сая төгрөг, татварын тооцоонд 25.3 сая төгрөг, НДШ-д 221.8 сая төгрөг нийт 550.1 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа. Цаашид компанийн орлогыг нэмэгдүүлж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах компанийн хувьцаа эзэмшигчдэд ноогдох ашгийг нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажиллах болно.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: 2024 онд Санхүүгийн тайланг алдагдалтай гарсан гэж байна. Ямар ямар зардал өсөөд алдагдалтай гарсаныг тодруульа Бямбажаргал? Ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал: Түрүүн тайланд дурьдсанаар үйл ажиллагааны зардалд хүснэгтээр харуулсан байгаа.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: 2024 онд хийгдсэн зам засвар, орох гарахын камерын тоног төхөөрөмж, Дархан зах, Шинэ зах, Буян зах, Шинэ орчин төвийн хяналтын камер зэрэг засварын ажлыг дагаад мөн өөрсдийн ажилчдаар нэмж гүйцэтгэх ажлуудыг хийлгэсэн ажлын хөлс, цалингийн зардал гэх мэтчилэн зардлууд дагаж гарсан.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Хичнээн төгрөгийн зардал яг хаана гараад байгаа тооцоог хэлнэ үү. Ерөнхийд нь байгууллага алдагдалтай ажиллаж. Цаашид зардлаа нарийн сайн ойлгогдохоор танилцуулах хэрэгтэй анхаараарай. Дараа жил алдагдалтай ажиллахгүй биздээ?

Гүйцэтгэх захирал, Хувьцаа эзэмшигч М.Оюун: Ашиглалтын зардал хэдэн хувиар өсөх, тэрэнтэй холбоотойгоор зардал өөрчлөгдөх учир шууд холбоотой.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Байгууллагаас авах авлагад ямар байгууллага байгаа вэ?

Компанийн нягтлан бодогч Бямбажаргал: Жишээ нь Хөдөө аж ахуйн "Момо Агро" ХХК аас 104 сая төгрөгний авлагатай байгаа.

Хувьцаа эзэмшигч Оюун: Ногдол ашиг хуваарилах эсэх тухай. ТУЗ нь хуралдаж ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрээ гаргасан. Иймээс энэ онд ногдол ашиг хуваарилахгүй гэсэн. Та бүхэнд санал байна уу.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Байхгүй.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Байхгүй.

Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй бол санал хураалтаа явуулъя. Тооллогын комисс саналын хуудсаа хувьцаа эзэмшигчдэд тараана уу. Санал хураалт явагдаж дүнг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Л.Энхсайхан танилцуулж, комиссоос гарах тогтоолоо танилцууллаа.

Хурлын дарга: Тооллогын комиссыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах тогтоолуудыг гаргахаар болж байна Та бүхэнд танилцуулъя.

Үүнд:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан,
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье.

Хураалт 16:00 цагт өндөрлөж байна

Хурлын дарга:

Хувьцаа эзэмшигч:

/Ж.Очирсүх/

/М.Оюун/

/М.Цолмон/

/Л.Амарсанаа/

Хараат бус гишүүн

/Д.Бумцэрэн/

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: /Э.Жавхлантөгс/